



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНКНЫ ТОС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ

2023

2-Р УЛИРЛЫН ТАЙЛАН



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг билээ. Бид өөрсдийн санхүүжүүлэх төсөлд ч энэхүү шалгуурыг тавьж, дэмжин ажилладаг бөгөөд уг зорилгын хүрээнд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэн орж, 2015 оноос ТоС хөтөлбөрийн албан ёсны гишүүнээр элсэн орсон. Түүнээс хойш Богд банк өдөр тутмын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг үргэлж тусгаж ирсэн.



НОГООН ОРЧИН I

Богд банк нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд СХД-ийн Бумбатын булагт тарьж байсан модоо услах, нөхөн сэргээх ажлыг хийлээ.

Тодруулбал, 2021 онд арилжааны банкууд нь Монголын банкны холбоо болон Монголбанктай хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Бумбатын булаг хэмээх газар 2000 мод тарьж байсан. Банк санхүүгийн салбарын төлөөлөл 2030 он гэхэд 50 сая мод тарих зорилт тавьсан бөгөөд үүний хүрээнд жил бүр шинээр мод тарих, өмнө нь тарьсан модоо услах, арчлах ажлыг тогтмол хийж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлснээр ойн сан нэмэгдэж, хүлэмжийн хийн ялгарал буурахаас гадна нийгэм, эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлэх юм.

Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд банк санхүүгийн салбарын үүрэг оролцоо чухал бөгөөд Богд банк нь байгаль орчин, нийгэмд ээлтэй бүхийл үйл ажиллагааг дэмжин ажиллаж, харилцагч нартаа ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож байна.



НОГООН ОРЧИН 2

Монголын банкны холбоо, арилжааны банкууд болон Монголбанк хамтран өнгөрсөн онд "Тэрбум мод сан"-г байгаль орчныг хамгаалах, ойг нөхөн сэргээх, ойжуулах, мод тарих, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх зорилгоор хувийн санхүүжилттэй санг байгуулсан билээ.

Богд банк, бусад арилжааны банкууд болон Монголбанк нь бага дүнтэй банк хоорондын гүйлгээний шимтгэлийн орлогоос тодорхой дүнг Тэрбум Мод Сан руу сар бүр шилжүүлдэг ба уг санхүүжилтээр Тэрбум Мод Сан нь анхны төслөө зарлаж, сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлсэн билээ. Уг төслийн сонгон шалгаруулалтын комиссд Богд банк нь оролцож бид 2023 оны 05 сарын 18-ны өдөр иргэд аж ахуй нэгжийн ирүүлсэн нийт 200 гаруй төслөөс шалгарсан 34 төслийг олон нийтэд танилцууллаа.

Энэ жилийн төсөл сонгон шалгаруулалтад амжилттай оролцож, шалгарсан нийт төсөл хэрэгжүүлэгчдэдээ Тэрбум мод тарих их үйлсэд нэгдэн хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлэн Богд банкны Бизнес банк хариуцсан дэд захирал М.Алтанбагана батламжийг гардуулсан.

Төслийн хүрээнд 37 га талбайд нийт 105,000 гаруй модыг тарьж ургуулах, 20,000 мкв ногоон байгууламжийг бий болгохоос гадна 5 жилийн хугацаанд тогтмол арчилж, эргэн хяналтыг хийх юм. Түүнчлэн 70 гаруй шинэ ногоон ажлын байрыг бий болгож, 3 төрлийн шинэ технологи, инновацын шийдлийг нэвтрүүлж, төрийн өмчийн сургууль цэцэрлэгийн 18,000 гаруй хүүхэд, сурагчдыг ногоон орчинд сурч боловсрох боломжоор хангах юм.

Цаашид Богд банк нь Тэрбум мод сантай хамтран хөнгөлөлттэй нөхцөлтэй ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгох, бусад гадаад, дотоодын эх үүсвэрүүдийг судалж ойн салбарт хувийн болон олон улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Богд банк нь Тогтвортой санхүүжилтийн хүрээнд 2023 оны 2-р улиралд "Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим"-тай ЖДҮҮ-ийн салбарыг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох зорилготой хамтран ажиллах санамж бичигт, "Зээлийн батлан даалтын сан"-тай Азийн хөгжлийн банкны төслийн эх үүсвэртэй батлан даалттай зээлийн бүтээгдэхүүнийг зорилтот харилцагчдад хүргэх санамж бичигт тус тус гарын үсэг зурж баталгаажууллаа.

Бид Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд "Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан бизнесийн зээл", "Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээл", "Ногоон хэрэглээний зээл", "Эко автомашины зээл" болон "Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй батлан даалттай төслийн зээл"-ийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэн Тогтвортой санхүүжилтийг дэмжин ажиллаж байна.

ИЛ ТОД БАЙДАЛ

Богд банк нь Банкны тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу олон нийтэд жилийн болон хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа хүргэдэг билээ. Уг тайланд бид 2023 оны хагас жилийн Тогтвортой санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлсэн ажлын тайланг тусган ил тод байдлыг баримтлан ажиллаж байна.



ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ

Богд банк нь эх дэлхийдээ ээлтэй, нийгэмдээ эерэг, залуусын амьдрах хэв маягт шинэчлэлтэд хувь нэмрээ оруулах зорилгын хүрээнд "Update Festival 2023" ивээн тэтгэж хамтран ажиллалаа. Уг арга хэмжээ нь дэлхийн дунджаас 176 дахин бага нүүрсхүчлийн хийг ялгаруулсан анхны арга хэмжээ бөгөөд нийт 15,000 залуусын нэгтгэж чадсанаараа онцлог болсон арга хэмжээ юм.

